

**Тоосгоны шаврын ” Налайхын уурхайн зүүнжигүүр ”ордын 2023 онд
Байгаль Орчны Менежментийн төлөвлөгөөнд доор дурьдсан ажлуудыг
тусгалаа.**

1. Танилцуулга

2. Тоосго үйлдвэрлэлийн сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээний

төлөвлөгөө

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

5. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

7. Байгаль орчны менежментийн систем хууль эрх зүй

8. Ашигласан материал

9. Хяналтын хуудас

10.Хавсралт материалууд

1. ТАНИЛЦУУЛГА

Хуалян ХХК нь 2002 онд байгуулагдсан. 2004 оноос Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутагт 4508А тоот Ашигт малтмал ашиглах Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Налайхын уурхайн зүүн жигүүр шаврын орд газарт 21 дахь жилдээ Тоосгоны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг үр ашигтай явуулж байна.

1.1. Эдийн засаг дэд бүтцийн товч тодорхойлолт

Налайх тосгон нь 8000 гаруй өрхийн 28000 хүн амтай бөгөөд халх,казак, буриад, урианхай дөрвөд зэрэг үндэстэн ястан оршин суудаг. Налайх тосгонд соёлын ордон, эмнэлэг,дэлгүүр,зоогийн газрууд, харилцаа холбоо, зочид буудал,халуун ус, үсчин гоо саахан 11 жилийн сургалттай ЕБСургуулиуд МСҮТ,хувийн бага болон дунд сургуул, хувийн хэвшлийн нүүрсний уурхайнууд, цахилгаан станц,малын гаралтай түүхий эдийн зах,гадаадын болон хувийн хөрөнгө оруулалттай оёдлын,тоосгоны, цементийн, блокны, хуванцарын зэрэг үйлдвэрүүд болон үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг газрууд олон бий.Нийтийн зориулалттай 2-5 давхар орон сууцнууд дүүргийн 17%-ийг эзэлдэг.Налайх тосгон нь чиглэлийн автобус, бусад машин техникийн саадгүй үйлчилгээтэй мөн зүүн аймгуудын автомашины гол зам дайран өнгөрдөг тул зүүн аймгуудтай харилцах зам харилцааны зангилаа болдог. Мөн Улаанбаатар Замын – Үүдийн хатуу хучилттай мянганы зам тосгоны баруун талаар дайрч өнгөрдөг.

“ Налайхын уурхайн зүүн жигүүр” шаврын орд нь эдийн засаг, зам харилцааны хувьд дэд бүтэц сайн хөгжсөн бүсэд байгаа бөгөөд талбайд байрлах 100кВт-ийн цахилгаан дамжуулах агаарын шугмаас өөрийн 10/4кВт-ийн трансформаторыг суурилуулж үйлдвэрийн хэрэгцээт хүчдэлийг авч эрчим хүчний асуудал бүрэн шийдэгдсэн.Цахилгаан хүчдэлийг,дамжуулах хувиарлах байгууламж, бусад цахилгаан тоног төхөөрөмжийг богино холболтоос хамгаалж АВ серийн автомат салгуур залгуур бүхий алсын удирдлагатай тоног төхөөрөмжийг хэрэглэсэн болно.

Гэрэлтүүлэг агааржуулах сэнсийг QBZ/BQD-80Z/автоматаас авч тэжээнэ.

Үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа хэвийн цаашид тоног төхөөрөмжүүдээ шинэчлэлгүй 10 жил үйл ажиллагаа явуулах боломжтой байна.

Тус үйлдвэрлэлийн ажиллах хүчний хувьд Налайх дүүргийн ХХҮХэлтэстэй гэрээ хийн улирлын чанартай ажиллах 40-50 ажилчинг ажиллуулдаг болно.

“Хуалян”ХХК нь “Налайхын зүүн жигүүр”-ийн шаврын ордод 2002,2009 онд геологийн хайгуул хийж талбайн нийт тоосгоны шаврын нөөцөөс үлдсэн $V = 606105 \text{ м}^3$ бодитой нөөцөөр тооцож “Аргай-Оч” ХХК ТЭЗҮ-ийг боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 08-р сарын 13-ний өдрийн хуралдаанаар баталгаажуулсан. Урьд жилүүдэд ашиглан тоосгоны шавар олборлолт хийж байсан талбайг үргэлжлүүлэн 2023 онд олборлолт хийнэ. Олборлолтын ажлыг хийхдээ манай орны уул уурхайн салбарт ашиглагдаж байгаа өндөр хүчин чадалтай машин механизмуудаар хөрс хуулалт, шавар олборлолтыг хийж гүйцэтгэнэ.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг 5-р сараас 9-р сарын 15 хүртэл хугацаанд явуулна. 2022 онд **ажиллах хүчин дутагдалтайгаас** хүндрэл үүсч төлөвлөгөөний дагуу олборлолт үйлдвэрлэл явагдаагүй болно.

2023 онд “Налайхын зүүн жигүүр”-ийн шаврын ордын В-1 блокоос 7220 м^3 шавар олборлон урд онуудад бэлтгэж нөөцөлсөн 3190 м^3 шавар нийт 10410 м^3 шавраар 3.0 сая ширхэг тоосго үйлдвэрлэх болно./Нөөцийн В-1 блок нь **2023 оны 01-р сарын 01-ний байдлаар үйлдвэрийн $V_1 = 28763 \text{ м}^3$ нөөцтэй/**

Үйлдвэрлэлийн зардлыг үйлдвэрлэл ажиллах хугацаагаар тооцож тухайн жилийн төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэхийн тулд тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг чанар сайтай хийж,эдийн засгийн чадавхи, үйлдвэрлэлийн технологийн горим, ажилчдын ажиллах ажилтануудын идэвхи санаачилга хөдөлмөрлөх ур чадварыг дээшлүүлэх, ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн амьдрах, хөдөлмөрлөх нөхцлийг шаардлагын хэмжээнд хүртэл сайжируулснаар төлөвлөгөөт зорилтыг хугацаандаа хийж гүйцэтгэх болно.

Ашиглалтын үед ашиглалтыг зузаан ихтэй бохирдол багатай үе давхаргыг сорьцлон ашиглахгүй ашигт малтмалыг зүй зохистой ашиглах талаар анхаарч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулна.

1.2. Байгаль орчны төлөв байдал

Тоосгоны шаврын ордын талбай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт орших ба Улаанбаатар хотоос 37 км-т Налайхын нүүрсний уурхайн зүүн хойт зүгт 1,2км-т оршино.

Газарзүйн байршил нь:

1.	47° 45' 24''	107° 17' 45''
2.	47° 45' 33''	107° 17' 45''
3.	47° 45' 33''	107° 18' 35''
4.	47° 45' 24''	107° 18' 35''

Тоосгоны шаврын орд доод цэрдийн зүүн баянгийн давхрагын шаварлаг, занарлаг доод зузаалгад хамаарагдах давхраас маягийн биет юм.

Ордын ашигтай зузаалаг болох хар саарал, саарал ангийн шаврын зузаан нь ордын талбайн баруун хэсэг болох В₁- блокын хэмжээнд 3,1м, хөрсний зузаан 2,31.

Ордын хэмжээнд олборлолт явуулах явцад ямар нэгэн чулуужилт, цэвдэг, хөөрөлт, нуралт зэрэг ноцтой хүндрэл учрахгүй.

Налайхын нүүрсний орд газар нь Физик газарзүйн мужлалаар Хэнтийн нурууны зүүн өмнөд хэсэгт багтах бөгөөд дунд зэргийн хэрчигдэл бүхий нам уулс, тал хээрийн бүсийн намхан толгодорхог гадаргуутай, далайн түвшнээс дээш 1440-1450 метрт өргөгдсөн. Жилд дунджаар 220 мм орчим тунадас унадаг.

Цаг уурын хувьд эх газрын эрс тэрс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур эрс хэлбэлзэлтэй атмосферийн хэлбэлзэл ихтэй, Жилд дунджаар 220 мм орчим тунадас унах бөгөөд хур тундасны ихэнх нь 7-8 сард унадаг. Анхны цас 9-р сарын 15-ний үеэр сүүлчийн цас 5-р сарын 15-ний үеэр орох жишээтэй.

Налайхын орчимд агаарын дундаж температур хамгийн хүйтэн 1 дүгээр сард -27°C, хамгийн дулаан 7 дугаар сард +20-25°C орчим байдаг. Өвөл хөрс нь 3-5м гүн хөлддөг. Мөн газар хөдлөлтийн VII-VIII бүсэд оршдог.

Мөн цэвдэг нилээд өргөн хэмжээгээр тархсан бөгөөд цэвдэгийн гүний хэмжээ нь газрын хотгор гүдгэр болон чулуулгийн найрлага, литологийн бүтцээс хамаарч, нам дор хэсэгт 1.54-2.0 м, өргөгдсөн хэсэгт 3-5 м хүрч байна. Мөнх цэвдэгтэй газрын хөрсний ус нь агаарын тунадас ба орчмын гүний усны урсгалаас голлон тэжээгддэг байна. Тус ордоос 8 км зайтай Туул гол урсдаг бөгөөд ордын орчимд булаг шанд байхгүй усны сүлжээ муу хөгжсөн.

Налайхын хотгорын газар доорхи усыг дунд төмөрлөгийн хурдсанд нь агуулагдах нүүрсний, үйлдвэрийн ач холбогдол бүхий орд газартай нь холбон тусгайлан судалсан. Дунд төмөрлөгийн хурдсанд ус агуулах тогтвортой үеүд бараг байдаггүй. Усны оршилтын гүн ихээхэн хэлбэлзэнэ. Налайхын хотгорт энэ үзүүлэлт 31,0-64,5м-ийн хооронд хэлбэлздэг.Цооногуудын ундарц голдуу 1-2л/сек-ээс хэтрэхгүй.

Уг ордыг олборлолтын явцад ахуйн хэрэгцээний ус болон тоосго зуурахад шаардагдах усыг 2006 онд өрөмдсөн 130 м гүнтэй, 1,3л/сек ундрагатай гүний тоноггосон худгаас хэрэглэх тул ямар нэгэн хүндрэл гарахгүй.

2009 онд Налайх дүүргийн засаг даргаар ус ашиглах захирамж,2010 онд Нийслэлийн Байгаль Орчны Газраас Ус ашиглах дүгнэлтийг гаргуулан авсан .

2016 оны 03 сарын 29-ны өдөр НБОНХГазрын Дугаар 08 тоот Ус ашиглах дүгнэлтийг гаргасны дагуу жилд 435120 төгрөгийг төлж байна.

2021, 2023 онуудад НБОГ-р ус ашиглах дүгнэлт гаргуулан тоолуурын заалтаар усны төлбөрөө төлж байна.

2021,2023 онд Туул голын сав газрын захиргаанаас гаргасан ХУД/50 тоот дүгнэлтийн дагуу Налайх дүүргийн “ Чандмань-Налайх”ОНӨГазартай жил бүр гэрээ байгуулан 198200 төгрөг төлж бохироо зайлуулан ажиллаж байна.

Улаанбаатар хот орчмын газар нутаг нь хөрс газарзүйн Хангайн их мужийн Хангайн төвийн районы баруун өмнө захын хэсэгт хамаарагдана.Энд уулын хар хүрэн, хүрэн, нугын хүрэн, хээрийн хүрэн хөрс тус тус тархах бөгөөд хээрийн хүрэн хөрс зохилох байр суурийг эзэлж байна.Тоосгоны үйлдвэр, шаврын ордын орчмоор хээрийн хүрэн хөрс тархсан байна. Хөрсний сорьц дээжинд ХААИС-ийн Хөрсний химийн лабораторид хийсэн шинжилгээний дүнг авч үзвэл:

Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд

Шаврын орд	Гүн, см	100 г хөрсөнд мг				PH
		NO ₃	P ₂ O ₃	K ₂ O	Ялзмаг %	
	0-20	1.00	1.44	8.52	1.67	7.40

Ул хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн

Гүн (см)	10.0	7.0-5.0	5.0-2.0	2.0-1.0	1.0-0.5	0.5-0.25	0.25-0.10	0.10-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005>	Тайлбар
0-20	-	6.6	3.8	17.9	1.4	4.8	1.0	5.1	7.4	2.5	1.7	Хөнгөн элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй

100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор, азотын хангамжаар ядуу, калийн хангамжаар дунд зэрэг, ялзмагийн хэмжээ бага, ерөнхийдээ үржил шимээр ядмаг, хөнгөн элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хүрэн хөрс уусмалын орчин (РН 7.40) сул хүчлэг байна.

Хөрсөнд ахуйн болоод нефтийн бүтээгдэхүүний бохирдол үүсээгүй болно.

Тус бүс нутагт Улаанбаатар хот байгуулагдан аажмаар өргөжин тэлэхийн хирээр үржил шимт хөрсийг бүрэн түрж Туул голын далан хийх, үйлдвэр байгуулах, хот барилгажих явцад өнгөн хөрс хуулагдаж, хүний үйл ажиллагаа ноёлж байгаагаас тус нутгийн унаган хөрс ургамлын экосистем бүрэн алдагдаж түүнийг орлож хөрсний үржил шимт үе давхарга хүний үйл ажиллагаагаар үүссэн элс, хайрга, шорооноос тогтох болсон. Мөн дэд бүтцийн салбар дахь хөгжлийг дагалдан үйлдвэр аж ахуйн газар уурхайнууд, орон сууцны хороолалууд нэмэгдсэнээр эдэлбэр нутаг, хүрээлэн байгаа орчиндоо үзүүлэх сөрөг нөлөө улам бүр өссөөр ирлээ.

Ийнхүү тус бүр нутагт амьтан ургамлын аймгийн экосистемийн шинж төрх бүрэн алдагдаж, энэ хавийн амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин хүний ойр орчимд амьдардаг синантроп зүйлүүд суурьших болжээ. Энэ нь цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн энэ хэсэгт явуулсан ажиглалт, хүмүүсийн яриа, газрын гадаргын шинж байдал, хотжилтонд хамрагдсан байдал зэргийг харгалзан амьтны аймгаас төрөл зүйлээс хамгийн өргөн тархсан хөхтөн, шувуу, шавьжийн дараах цөөн зүйл байна. Үүнд:

Хөхтөн амьтнаас:

Гэрийн хулгана, үлийн цагаан оготно, хэргэлзий оготно

Шувууд:

Сохор элээ,шоорон алаг болжмор,хар хэрээ,хон хэрээ,турлиах,алаг шаазгай,хээрийн бор шувуу,оронгийн бор шувуу

Ургамлын аймаг

Улаанбаатар хотын орчмын өвслөг ургамлан нөмрөгтэй хэв шинжүүдийн биобүтээмж нь тухайн бүлгэмдлийг бүрдүүлэгч ургамлын биологи, экологийн онцлог, ашиглалтын байдал. талхагдлын зэргээс хамаарч хэлбэлзэл ихтэй байна. Энд хүний үйл ажиллагаа төдийгүй уул толгодын орой энгэрийн нимгэн хөрсөн бүрхүүл үерийн усанд угаагдаж, ул чулуу ил гарч хайрга дайргын туугдмал хурдас үүлын бэл хормойгоор элбэгшиж уул нуруу гүвээ тал хөндий хаа сайгүй гуу жалгаар хэрчигдэж байна. Ургамлын нөмрөгийн унаган төрх алдагдаж, малын тэжээлийн өндөр ач холбогдолтой зүйл ургамлууд хомсдож мал огт иддэггүй шарилжийн зүйл төрөл, арзгар согоолж мэтийн талхагдалтыг илархийлэгч ургамлаар солигдож байна. Налайх дүүрэг нь уулсын хоорондохи уудам газар нутагтай.

Дүүргийн төв хэсэгт орших нуурсний уурхайг нийслэл хотын айл өрх, цахилгаан станцуудыг нүүрс хангах зорилгоор 90 жилийн өмнөөс олборлон ашиглаж ирсэн билээ, Хүн амын суурьшил ч жил ирэх тутам улам нэмэгдсээр, хот улам тэлж хөгжсөөр байна. Энэ бүхнээс хөрс машин механизм тээврийн хэрэслэлийн хөдөлгөөн, суурьшил, хүний үйл ажиллагаатай холбоотойгоор ихээхэн эвдэрч элэгдэж талхлагсан юм Энд ургамлын зүйл төрөл хомсдож цөөрөхийн зэрэгцээ шинээр байгалийн зохисгүй нөхцөлд ургадаг хогийн ургамлын зүйл төрөл их ургах болжээ.

Ордын ургамлын аймгийн зүйлийн бүрэлдэхүүн

Цагаан лууль, өргөст лууль,ацан ажигана,мөлхөө гичгэнэ,хурган шарилж, ямаан шарилж,нарийн навчит халгай, ленийн ботууль, мөлхөө шээргэнэ,шивээт хялгана,мөлхөө улалж,хялгасан улалж, уул өвс, ганга, бэвлэнцэр, хиаг, багваахай, монгол өвс, бургас навчит банздо, том навчит тавал салаа

1.3.Ордын геологийн тогтоц

“Налайхын зүүн жигүүр”-ийн шаврын орд нь Налайхын нүүрсний уурхайн балгасаас зүүн хойт зүгт 1,2 км-ийн зайтай нам доор газар байрлана. Ордын геологийн тогтоцын хувьд Зүүнбаянгийн давхаргын шаварлаг занарын зузаалаг болох

хар саарал өнгийн алевролит, аргиллит, шавар хааяа элсэн чулуулгийн үеүд ордын орчимд тархсан ба эдгээр чулуулгуудыг хучсан дөрөвдөгчийн насны наанги шавар, хааяа хайрга, хайрганцар, элсэнцэр, бүхий хэмхдэс сэвсгэр хурдас тархжээ.

Шавар нь хотгорыг хүрээлж байгаа уулын хажуу бэлээс зөөгдсөн болдоод цэрдийн настай Зүүнбаянгийн давхаргадсын нүүрслэг зузаалаг, түүний доорхи хэсгийн аргиллит, алевролитлаг чулуулагын өгөршлийн гадаргууд шавар, шаварлаг бүрдлээр баяжигдсан пролювийн гаралтай юм.

Шаврын дээд хэсгийн хуулах үржил шимт үе болох хар шороон хөрс нь 0,20 м зузаантай бөгөөд талбайн хэмжээнд дунджаар 0,20 м байна. Шавар нь бор шаргал, цайвар- саарал, бор хүрэн өнгөтэй, хайгуулиар илрүүлэгдсэн зузаан нь 3,10м. Шавар дахь элсэрхэг хэсгийн агуулга нь дундажаар 12,06%- тоосорхог хэсгийн агуулга 29,63%, шаварлаг хэсгийн агуулга нь 58.30% байна.

Шавар бохирдол хэсэг болох 0,5-1,0 мм хэмжээтэй хэмхдэс материал – 1.04% 5мм-с их хэмхдэс материал -0.3% эзэлнэ.Шаврын давхаргын дунд шаргал, саарал өнгөтэй чулуулгийн хэмхдэс, мөхлөг агуулсан маш нимгэн, мэшил маягийн 0,05-0,10 м орчим зузаантай элсэнцрийн үе тохиолдоно.

Шавар нь давхарга маягийн хэвтээ байрлалтай, заримдаа үл ялиг үелэг тогтоц ажиглагдана. Шаврын уланд шаварлаг элсэнцэр материал жигд тархсан байна. Ордын шаварт том хэмжээтэй бохирдолт болох чулуулаг нь ихэвчлэн занар, аргиллит, алевролит болно. Харин тоосгоны шаварт карбонатлаг, шохойлог, кальцитлэг хольц бага химийн шинжилгээгээр СаО-ийн агуулга 2,10 байна.

1.4.Боловсруулалтын хаягдал

Хаягдалын шинж чанар

Тоосгоны шаврын хольцыг бутлах, ангилан шигшихэд технологийн хаягдал болох нарийн ширхэгтэй чулуулгийн үлдэгдэл далан хэлбэртэйгээр үүсэх бөгөөд энэхүү хаягдал нь ямар нэгэн химийн хорт бодис агуулахгүй учраас гадаргад ил гарсны дараа гадаргын усны нөлөөгөөр агаарын болон хөрсний рН-ийн тэнцвэрт байдлыг өөрчлөх сөрөг нөлөө үзүүлэхгүй.Үйлдвэрлэлийн явцад гарч байгаа технологийн хаягдал цагаан тоосгыг дахин буталж үйлдвэрлэлтэнд ашигладаг орчинд бохирдол хаягдал болохгүй.

Хаягдлын овоолго, далан

Уурхайг ашиглаж дууссаны дараа уурхайн эдэлбэр талбайд ямар нэг овоолго, хаягдлын үлдэгдэл үлдэхгүй болно. Уурхайг ашиглах явцад шаврын хаягдлыг шаврыг авсан хөндий орон зайд хийж булах ба жил бүрийн хөрс хуулалтаас гарсан хоосон шороог ашиглагдсан талбайд түрж хийж талбайн нөхөн сэргээлтийг хийнэ. Харин хөрс хуулах үед дээд хэсгийн 0,20 м-ийн үржил шим бүхий хөрсийг тусгайлан хуулан авч 2023 онд гарсан **”Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”**-ын дагуу хадгалж техникийн нөхөн сэргээлт хийж дууссан талбайд хэсэгчлэн хучиж нөхөн сэргээлт хийнэ.

Хаягдлын менежмент

Ашиглалт дууссаны дараа шаврыг авсан талбайн ирмэгийг 10-13⁰ хүртэл налуутай болгон тэгшлэн техникийн нөхөн сэргээлтийг хийсний дараа биологийн нөхөн сэргээлтийг хийж талбайг ургамалжуулна. Ахуйн үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг тусгайлан хадгалан цуглуулж дууссаны дараа Налайх дүүргийн төвлөрсөн хогийн цэгт өрсдийн унаагаар тээвэрлэж хаяна.

1.5.Уурхайн хүчин чадал

Шавар олборлох, боловсруулах үйлдвэр, уурхайн хүчин чадлыг хамтран ажилладаг үйлдвэрүүдийн хэрэгцээ шаардлага, бэлэн байгаа тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал зэрэгт тулгуурлан тооцож үзэхэд 2023 оны байдлаар талбайн тоног төхөөрөмжийн жилийн хүчин чадал дунджаар 2.5-4.0 сая тоосго үйлдвэрлэж байхад хангалттай бөгөөд энэ хүчин чадал нь төслийн явцаас хамааран нэмэгдэх боломжтой.

Налайхын шаврын зүүн жигүүрийн ордын уул-геологи болон уул-техникийн нөхцлийг харгалзан тээвэрлэлттэй тээвэргүй ашиглалтын систем, ил аргаар явуулахаар сонголоо. Хөрс хуулалтын ажилд ZL-50E маркийн түрэгч, ачигч 1ш, HOWO маркийн өөрөө буулгагч автомашин ашиглана. Ашиглалт явуулах хэсгийн хөрсний үржил шимтэй дээд хэсгийн 0.2 м зузаантай хөрсийг хуулан авч 480м³ үржил шимт хөрсний овоолго хийнэ.

2023 онд 5260м³ хөрс хуулж, хөрсний, 100% -ийг дотоод овоолго хийх буюу техникийн нөхөн сэргээлтэнд ашиглана.Хөрс ухаж ачин, тээвэрлэх, овоолох процессод ZL-50E маркийн, ухагч, түрэгч зарим тохиолдод KV-25 маркийн өөрөө буулгагч автомашин, ашиглах бөгөөд хөрсийг хуулж бэлэн болгосон хэсгийн шаврыг

ZL-50E-аар хутган зөөж авчирч бутлан ангилах төхөөрөмжийн дэргэдэх шавар хураах хэсэгт хүргэнэ.

Мөргөцгийн гүн нь ашигт давхарга буюу шаврын зузаанаас хамаарч 5,50 м хүртэл гүнтэй, мөргөцгийн налуу нь шаврын дотоод гулсалтын өнцөг буюу 75-80⁰-аас ихгүй байна.

Олборлолтын хүчин чадал

Олборлолтын хүчин чадалд нөлөөлөх хүчин зүйлс нь ордын тогтоц, нөөц болон уулын цулын хэмжээ зэрэг болно.

Ордын тогтоц энгийн тогтоцтой хэдий ч шаварлаг тоосорхог хэсгийн агуулгаас хамаарч орон зайн хувьд тусгаарлагдаж байгаа нь хөрсний дотоод овоолго үүсгэх, нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг багасгах зэрэг боломжийг бий болгож байна.

Хөрс хуулалтын хүчин чадал

Хөрс хуулалтын хүчин чадал нь олборлолтын хүчин чадлаас шууд хамаарах бөгөөд бэлэн байгаа уул-тээврийн бүтээл өндөртэй тоног төхөөрөмжийг сонгосон. Ордын хэмжээнд хөрс хуулалтын коэффициент 1: 0,80% байгаа нь хөрс хуулалтын ажлыг бүтээмж өндөртэй техникээр хийхэд цаг хугацаа хожих боломжийг бий болгож байна.

1.6.Уулын ажлын горим

“Хуалян” ХХК-нь “Налайхын зүүн жигүүр” -ийн шаврын ордоос шавар олборлож тоосгоны үйлдвэрлэл явуулана. Тоосгоны үйлдвэр нь 5 сарын 15-нээс 9 сарын 15 хүртэл 4 сарын хугацаанд албан ёсны амралт, баяр ёслолын өдрүүдээс бусад өдрүүдэд, ажлын цагийн үргэлжлэх хугацаа 8 цаг хоногт 1 ээлжтэйгээр ажиллана.

Тоосгоны шавар олборлох карьерийн гүнийг геологийн нөөц тогтоосон 5,5 метр хүртэл байхаар тооцоолж байгаа бөгөөд захиалагч байгууллагуудын хэрэгцээнд шаардлагатай тоосгыг жилийн турш тогтмол хангаж байх асуудлыг олборлолт, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын гол үндэс болгон авлаа. Уурхайн үйлдвэрлэл нь олборлох, боловсруулах хэсэг буюу ил уурхай, хэрэглэгчидэд борлуулах цэгт хүргэх гэсэн үндсэн хэсгээс тогтоно.

1.7.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

Технологийн дараалал

Ордоос ил аргаар шаврыг олборлон бульдозероор түрж овоолго үүсгэсэн ба хувиарлагч бункерээр дамжуулан чулууг ялгах шигшүүрт өгнө. Ялгалтаар цэвэр шавар гарах бөгөөд үүнийг үйлдвэрлэлийн туузан зөөгүүрээр дамжуулан бутлах 1-р тээрэмд хүргэнэ.1-р тээрмээр бутлагдсан шаврыг мөн 2-р тээрэмд туузан дамжуулагчаар дамжуулна. 2-р тээрмээс гарсан шавар нь зуурагч машинд орох ба тогтсон хэмжээний чийглэгт хүргэн усыг хольж жигд хутган зуурмагыг бэлтгэнэ.Бэлэн болсон зуурмаг туузан дамжуулагчаар дамжин сорох вакум бүхий шахах прест орно.Нягтруулан шахсан шавар нь хэвлэх хошуугаар дамжин таслагчид очно. Стандартын хэмжээгээр таслагдсан түүхий тоосгыг зөөгч бага оврын машинаар зөөж хатаах талбайд хүргэнэ. Хатаах талбайд хатсан тоосгыг шатаах баюунд оруулж шатаана. Бэлэн болсон тоосгыг борлуулалтын талбайд зөөж хураана.

Хөрс хуулалтын технологи

Ашиглалтын үед хөрсийг лоадераар хуулж шууд ашиглагдсан орон зайд дотоод овоолгыг үүсгэнэ. Дотоод овоолготой ашиглалтын технологийг хэрэглэснээр хөрс хуулалтын өртөг зардлыг бууруулах, нөхөн сэргээлтийн ажлыг хямд өртөг зардлаар гүйцэтгэх боломжийг олгоно.

Олборлолтын технологи

Элс олборлох ажил нь ухаж ачих, тээвэрлэх болон шавар боловсруулах төхөөрөмжид ачаалах зэрэг процессуудаас бүрдэх бөгөөд олборлолтын доголд шаврыг лоадераар ухаж, тээвэрлэн шавар боловсруулах талбайд хураах бөгөөд хураасан шаврыг дугуйт ачигч, түрэгчээр шавар ангилан ялгах төхөөрөмжид ачаалан боловсруулах процесст оруулна.

Шаврын давхаргыг олборлох явцад хяналтын дээж авалтын ажлыг сайтар зохион байгуулан тогтмол хийж байх болно.

Шавар олборлолтын ажилд ZL-50E маркийн ачигч ухагч, ашиглах бөгөөд хөрсийг хуулж бэлэн болгосон хэсэгт лоадераар ачиж, шавар бутлан ангилах төхөөрөмжийн дэргэдэх тоосгоны шавар хураах хэсэгт хүргэнэ.

Мөргөцгийн гүн нь ашигт малтмалын давхарга буюу шаврын зузаанаас хамаарч 2,10-2,50 м хүртэл гүнтэй, мөргөцгийн налуу нь шаврын дотоод гулсалтын өнцөг буюу 30⁰-аас ихгүй байна.

Тоосгоны шаврыг ангилах, бутлан боловсруулах төхөөрөмжийн ойролцоо шавар хураах хэсэгт хураасан шаврыг ZL-50E дугуйт ачигчийн тусламжтайгаар шавар шигшин ангилагчид хүргэж, ялгасан шаврыг ZL-50E маркийн дугуйт ачигчаар буюу гинжит трактораар бункерт хийж өгнө.


Хөрс ухаж түрэх процесс

Хөрс ухаж ачин, тээвэрлэх, овоолох процессод ZL-50E маркийн ачигч түрэгчээр ачих зөөх, зарим тохиолдолд KV-25 маркийн өөрөө буулгагч автомашин ашиглана. Уурхайн хүчин чадал, техникийн бүтээмж, бэлэн байдлын коэффициент зэргийг харгалзан хөрс хуулалт, овоолгын ажилд дээрхи тоног төхөөрөмжийг сонгон авсан болно.

Тоосгоны шавар ухаж, ачих процесс

Тоосгоны шавар олборлолтын ажилд ZL-50E маркийн ачигч, түрэгч ашиглах бөгөөд зарим тохиолдолд HOWO маркийн өөрөө буулгагч автомашинаар зөөнө.

Уурхайн боловсруулалтын технологи Тоосго үйлдвэрлэх технологи ажиллагаа



Ордоос ил аргаар олборлосон шаврыг ачигч түрэгчээр түрж овоолго үүсгэн бункерээр дамжуулан чулууг ялгаж шигшүүрт өгнө. Ялгалтаар цэвэр тоосгоны шавар гарах бөгөөд туузан дамжуулагчаар шавраа зөөвөрлөн шавар зуурах төхөөрөмжинд хийж цааш үйлдвэрийн процесс үргэлжлэн хамгийн сүүлд шатаах зууханд шатаагдсан тоосго гарч худалдан борлуулагдаж зах зээлд нийлүүлэгдэнэ.

Гадаргын уснаас хамгаалах арга хэмжээ

Уурхайн талбайд үер борооны ус орж ирэхээс хамгаалан 0,5км урттай хамгаалалтын суваг, шуудуу, уурхайн хүрээг тойруулан татна.

Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ

Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг уурхай дахь засвар үйлчилгээний хэсэгт засах ба ноцтой гэмтэл гарсан тохиолдолд Улаанбаатар хот дахь засварын баазад хийнэ.

Уурхайн замын ажил

Уурхайг нээгч малталтаар нээх тул уурхайн бүх тээвэр уурхайн үндсэн малталтаар дамжин явагдана. Уурхайгаас олборлосон тоосгоны шаврыг боловсруулах төхөөрөмж хүртэл 50-100 м замыг сайжруулан тээврийн автомашин явахад саадгүй болгоно.

Бэлэн болсон бүтээгдэхүүнийг тээвэрлэх процесс нь уурхайгаас гадагш тээврийн сайжруулсан замаар хийгдэх бөгөөд уг замын арчилгаа, усалгааг тогтмол гүйцэтгэнэ.

2. ШАВАР ОЛБОРЛОЛТ БОЛОН ТООСГО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Шавар олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байна. Нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, усанд үл нордогоос нордог хүртэлх хэмжээтэй тоос агаар, ургамлан нөмрөг, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө. Төслийн талбай болон түүний ойр орчимд тархах магадлалтай. Шатаах зууханд чанар сайтай нүүрс хэрэглэхгүй бол шаталт муугаас болон шатаах зуухны яндангийн шүүр муудсанаас утаа тортогтой гарч агаар чанарт нөлөөлнө. Уурхайд ашиглагдаж буй хүнд машин механизмаас ялгарах утаа хий нь агаарын бохирдлын эх үүсвэр болно.

Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөлөл

Шавар олборлолтын үйл ажиллагааны үед хөрс хуулалт их хэмжээгээр явагдаж, газрын хэвлийд хонхор үүсэн гүнээс гарах их хэмжээний хөрсний овоолго газрын хэвлий дээр бий болон газрын ландшафтад өөрчлөлт бий болно. Мөн шатах, тослох материал хөрсөнд нэвчиж хөрсний чанарыг муутгадаг.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Тоосгоны үйлдвэрлэлийн усны хэрэгцээг Гүний худгаас хангадаг. Ил уурхайгаас нилээд хэмжээний шүүрлийн ус ялгардаг. Хог хаягдал, бохир усыг зөвшөөрөлгүй хаях, шатах тослох материалын асгаралтын улмаас хөрсний бохирдол үүсч, цаашдаа газрын доорхи усанд нөлөөлж болзошгүй.

Ургамал ба амьтанд үзүүлэх нөлөөлөл

Шавар олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөг устаж, тус газарт нутагшсан амьтад амьдрах орчноо алдана. Ургамлан нөмрөг их хэмжээгээр устсанаас тухайн орчны агаарт өөрчлөлт орж, хуурайшилт бий болно. Уурхайн эдэлбэр газар, дэд бүтцийн зарим талбайн ургамал, амьтан өртөх магадлалтай.

Хог хаягдлын нөлөөлөл

Ажлын байрнаас хатуу (ахуйн хог хаягдал, хаягдал мод, төмөр, хуучин дугуй, сэлбэг), шингэн (ахуйн бохир ус, ашигласан тос, түлш шатахууны хаягдал) хог хаягдал гарна. Хатуу, шингэн хог хаягдал хөрсөнд ил задгай хаягдсанаас орчны хөрсийг, гүний усыг бохирдуулах боломжтой. Тухайн газрын хөрс, ургамал, амьтан нөлөөлөлд хамгийн түрүүнд өртөх магадлалтай. Аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан, Ахуйн хаягдал болон үйлдвэрээс гарах бохир усыг хяналтгүй хаясны улмаас орчны хөрс, газрын доорхи ус, ургамалжилтанд дам нөлөөлнө.

ОРДЫН ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХТАЙ ХОЛБОГДСОН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Шавар олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болдог тул хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэдэг учир хуурайшилт ихтэй улиралд зам талбайг тогтмол услан зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулж, олон салаа зам гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж байна. Шатаах зууханд чанар сайтай нүүрс хэрэглэж, шатаах зуухны яндангийн шүүрийг цаг тухайд нь сольж байсан. Уурхайд ашиглагдаж буй хүнд машин механизмаас ялгарах утаа хий нь агаарын бохирдлын эх үүсвэр болдог тул техникийн үзлэгт оруулсан, ялгаруулж буй хорт утаа нь стандартын түвшинд буй машин техникийг ашиглах, ашиглагдаж буй машин техникт үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх, яндан бүрт шүүлтүүр суурилуулж өгөх, тохиргоо техникийн горимыг сайтар мөрдөх, түлшний найрлага, чанар, стандартыг сайтар хянах, чанартай түлш хэрэглэх зэрэг арга хэмжээ авч байна.

Агаарын бохирдлыг багасгахын тулд хийх ажлууд

1. Шатаах зууханд чанарын шаардлага хангасан шахмал түлшийг ” Таван толгой” ХК-тай гэрээгээр авч ашиглана.
2. Шатаах зуухны утааны тоосролтыг багасгах шүүлтүүрийг үйлдвэрлэлийн явцад 3 удаа сольж тавьсан нь дотор нь ажиллах нөхцөлийг сайжруулж ажиллана.
3. Үйлдвэрийн талбай дотор, үйлдвэрийн ажлын байр, карьерийн орчимд тоосны агууламжийг Цаг уур, Орчны шинжилгээний газрын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторид хүсэлт гаргаж тодорхойлуулна.
4. Нүүрсийг шатаах зуухны хажууд буулгаж овоолго үүсгэн тусгай зориулалтын полиэтилен цаасаар битүү хучиж хадгалж хэрэглэж байна. Энэ нь нэг талд байгаль орчныг бохирдуулахгүйгээс гадна орчны ариун цэврийн байдлыг хангаж, ажилчдын эрүүл мэндэд сайн нөлөө үзүүлсэн ажил болж байна.
5. Хөрс хуулалтын ажлыг чийглэг ихтэй байсан 5,6,7,8-р саруудад хийж гүйцэтгэнэ.
6. Үйлдвэрлэлд ажиллаж байгаа машин техникүүдийн яндангуудад ажил эхлэхийн өмнө

шүүлтүүр тавина .

7. Хэрэглэгдэх шатах тослох материалыг компаниудаас авч стандартын шаардлагын дагуу хадгалж ашиглана.
8. Ажиллагсдад үйлдвэрлэлийн ажил эхлэхийн өмнө агаарын бохирдол, хөрс ургамал, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх , түүнийг бага байлгах арга боломжийн талаар сургалт хийнэ.
9. Ажиллагсдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор 7 хоног бүр амны хаалт олгож байна.
10. Үйлдвэрлэлийн талбайд хог хаягдлын сав байрлуулсан бөгөөд хатуу хог хаягдлыг 7 хоног бүр Дүүргийн төвлөрсөн хог хаягдлын цэгт зайлуулж байна.
11. Шатаах зуухны дотор термометр тавьж доторх температурт хяналт тавьж ажиллана.

Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Үржил шимт хөрсийг хуулан овоолго үүсгэн технологийн дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглаж эргэлтэнд оруулж байна. Хөрсний элэгдэл, эвдрэлийг нэмэгдүүлэхгүйн тулд зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулна. Автомашины зогсоолын талбайг тэгшлэн шатах, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх; Машин техникийн хөдөлгөөнөөр босох тоосны хэмжээг хамгийн бага түвшинд барихын тулд хучилтгүй замын гадаргууг засварлах, замыг услах, зөвшөөрөлтэй талбайд байгаа ашиглагдахаа больсон хуучин замуудыг нөхөн сэргээх ажил хийсэн.

Хөрсний бохирдлыг багасгах талаар хийх ажлууд

1. Тус шаврын ордыг 2004 оноос хойш ашигласан бөгөөд өнөөдрийг хүртэл тэр ухлага хийсэн талбайг өргөтгөх замаар олборлолт явуулж байсан 0.1 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 2023 оны ашиглах 0.219 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.
2. Олборлолтыг нөхөн сэргээлт хийхэд боломжтой байдал, шаврын зузаанаас хамаарч явуулна.
3. Үйлдвэрлэлийн талбайд тэмдэгшүүлэлтийг сайн хийж, ялангуяа тээврийн хэрэгсэл зорчих замыг тодорхой болгож тэмдэгшүүлнэ.
4. Шаврын нөөцийг нь авсан гүехэн газруудыг чулуулгаар дүүргэлт хийж мөргөцөгийн хажууг налуулалт хийж хөрсний нөхөн сэргээлт хийнэ.
5. Шавар намагтай газрыг хайрга асгаж янзалсан.
6. Үйлдвэрлэлийн орчимд тоосгоор хучилт хийж шалбааг үүсэхээс сэргийлж ажиллана.
7. Ордын орчимд нүүрсний уурхайн олборлолт хийж нөхөн сэргээлт хийлгүй орхивол өөрийн техникийг ашиглан эргүүлж булах ажил зохион байгуулана.

8. Хөрс бохирдвол хөрсийг хуулан авч хогийн цэгт хаяна.
9. Үйлдвэрлэлийн ажил эхлэхийн өмнө хийх сургалтын хөтөлбөрт ажилчдад хөрсийг бохирдуулах нь ямар хор нөлөөтэй болох талаар хичээл заана.
10. Хөрсний шинжилгээг Цаг уур, Орчны шинжилгээний газрын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторид хүсэлт гаргаж тодорхойлуулна.

Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Усны цогц бодлогын дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, холбогдох дэглэмийг мөрдөн ажиллаж байна. Усыг тоос дарах зорилгоор ашигладаг. Хог хаягдал, бохир усыг зөвшөөрөгдсөн талбай нүхэнд хийж, шатах тослох материалын асгаралт гаргаж хөрсний бохирдолгүй ажилласан нь гүний усанд нөлөөлөх нөлөөлөлгүй ажилласан болно.

Усны бохирдлыг багасгахын тулд хийх ажлууд

1. Хөрсөн дээр бохирдол үүсгэхгүй ажиллах талаар ажил эхлэхийн өмнө ажилчдад хийсэн сургалтаар тайлбарлан ойлгуулж техник эзэмшигч ажилчдаар гарын үсэг зуруулж баримтжуулж авна.
2. Үйлдвэрийн орчны хог хаягдлыг бороо үерийн усаар дамжин орж ирэхээс болгоомжилж цэвэрлэж байна.
3. Ус ашиглалтын төлбөрт 435120 төгрөг төлнө.
4. Усыг өөрийн үйлдвэрийн гүний худгаас хангаж байна.
5. Бохир усыг “Чандмань-Налайх” ОНӨГ-тай байгуулсан гэрээний дагуу 198200 төгрөгийг төлж зөөвөрлүүлнэ.
6. Усны шинжилгээг Цаг уур, Орчны шинжилгээний газрын Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторид хүсэлт гаргаж тодорхойлуулна.

Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ

Өнгөн хөрсийг хуулах үед тухайн газрын ургамлан нөмрөг, шавьж, жижиг мэрэгчид зэрэг амьтад үгүй болсон байна. Ургамлан нөмрөг их хэмжээгээр устсанаас тухайн орчны агаарт өөрчлөлт орж, хуурайшилт бий болдог тул уурхайн явцын нөхөн сэргээлтийг хийхдээ биологийн нөхөн сэргээлийг аль болох боломжтой талбайг хамруулан хийсэн. Хуулж авсан өнгөн хөрсийг стандартын дагуу овоолго хийн хэлбэржүүлэн хадгалж, явцын нөхөн сэргээлтэнд хэрэглэж байна.

Хог хаягдлын нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ

Ахуйн хаягдал болон үйлдвэрээс гарах бохир усыг хяналтгүй хаясны улмаас орчны хөрс, газрын доорхи ус, ургамалжилтанд дам нөлөөлдөг тул, аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэх байгаль орчны зөрчлийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯамаар батлуулж мөрдөж ажиллаж байна. Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан Уул уурхайн аврах албаар батлуулан хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

3.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уул уурхайн төслийн хүрээлэн буй орчны асуудал нь төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд уг төслийн хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах, холбогдох стандартуудад нийцүүлэх, уурхайн үйл ажиллагаа ба уурхайн хаалтын явцад төлөвлөгдөөгүйгээр үүсэн гарах ашиглалтын болон капитал зардлын улмаас үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулах замаар хүрээлэн буй орчны нөлөөллийг бууруулах чиглэлийг тодорхойлж энэхүү баримт бичигт тусгасан болно.

Одоогийн байдлаар төслийн техник эдийн засгийн үндэслэлд төслийн улмаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн боломжийн хэмжээнд урьдчилан тооцоолж, аль болох бага хэмжээнд байлгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах зүйлсийг тусгалаа. Үүнд:

- Орд нь хөрс хуулалт харьцангуй багатай ордод хамаарах тул хөрсний овоолгод харьцангуй бага талбай шаардагдах ихэвчлэн дотоод овоолгод буюу техникийн нөхөн сэргээлтэнд хэрэглэх бөгөөд төслийн шийдэлд ашиглалтын жилүүд дэх уулын ажлыг хэд хэдэн хувилбараар нарийвчлан төлөвлөсөн.
- Уурхайн олборлолтод өртөх, талбайн хөрсний чулуулгийн гадаад овоолгод “Байгаль орчин, Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.Нэр томъёон тодорхойлолт” / MNS 5914-2008 /, “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” / MNS 5915-2008 / стандартуудын дагуу 0,50га, нийт, үржил шимт хэсгийг 0.2 м хүртэл зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах ба уурхайг ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэнэ. Шимт хөрсний овоолгын эзэлхүүн 3,0 мянган м3 болох бөгөөд уурхайн баруун талын талбайд 1,20 м өндөртэй овоолго үүсгэн хадгална.

- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага / MNS 5917-2008 / 2023 онд ашигласан талбай, овоолгуудыг хэлбэржүүлэн техникийн нөхөн сэргээлтийн ажлуудыг үргэлжлүүлэн хийх бөгөөд урьд онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд”Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага / MNS 5917-2008 /-ын дагуу 2023 онд биологийн нөхөн сэргээлт хийх болно.

Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, чиглэлийг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайг тусгайлан байгуулж, онц шаардлагагүй зам гаргаж газрын гадарга эвдлэгдэхээс чанд сэргийлнэ.

Тус шаврын ордод 2023 оны олборлолт явагдсан 0.2 га талбайд Эвдэрсэн газар, хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийх бөгөөд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд 0.1 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийнэ.

Техникийн нөхөн сэргээлтэнд гарах зардал

Ää	Гарсан зардлууд	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг
1	Ажилчдын цалин	Хүн/өдөр	10	40.0	400.0
2.	Шатахууны зардал	л	340	3.64	1240 .0
3.					
	ДҮН				1640.0

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг фотожуулж тайланд хавсаргана.

2023 онд 0.1 га талбайд Биологийн нөхөн сэргээлт хийх бөгөөд санхүүжилтийг үйлдвэрлэлийн дотоод зардлаар хийх болно.

Нөхөн сэргээлийн ажил хийж дуусаад гэрээт байгууллага болох Уул уурхайн итгэмжлэгдсэн байгууллага “ ОБО ” ХХК-р хэмжилт хийлгэж техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг баталгаажуулан гаргана.

4.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт Зардал Мян.төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах Эрх зүйн баримт бичиг
Үйлдвэрийн хог хаягдлыг зайлуулах гэрээг Налайх Төхижилт үйлчилгээний газартай байгуулна.	Хог хаягдлын хэмжээ				396.0	Гүйцэтгэх захирал	Байгаль орчин хариуцсан ажилтан	Гэрээ байгуулах	Хог хаягдлын тухай хууль 2004 Компаний дотоод журам
Үйлдвэрийн Хог хаягдлын цэгийн бүрэн бүтэн байдалд анхаарч хяналт тавих	Хог хаягдлын цэг		Байгаа хог хаягдал		Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны баг	Байхгүй		Хог хаягдлын тухай хууль 2004
Бохир ус зайлуулах цэгт байгаа хаягдлыг төвлөрсөн цэг рүү зөөвөрлөх	Хог хаягдлын цэг		Байгаа хог хаягдал		198.2	Чандмань-Налайх ХХК Байгаль орчны баг	Байхгүй		Компаний дотоод журам, Хог хаягдлын тухай хууль 2004
Технологийн хог хаягдлыг дахин бутлаж үйлдвэрлэлтэнд ашиглах	Технологийн хаягдал Цагаан тоосго		Тухайн оны хуримтлагдсан хаягдал		Үйл ажиллагааны зардал	Технологи инженерүүд	Байгаль орчны баг	Хуримтлагдсан цагаан тоосго	Компаний дотоод журам, технологийн заавар
Бохирдсон хөрс шороонд бохирдлын хэмжээг лабораторийн аргаар тодорхойлуулах	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хэсэгт		Бохирдсон хөрс шороо		Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны баг	Дүүргийн МХХэлтэс	Энэ жилийн бохирдсон хэмжээ	MNS 5850:2008 –хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

5.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техник технологийн зохион байгуулалтын арга хэмжээ	Гүйцэтгэх хугацаа	Хяналт тавих тайлагнах мэдээллэх	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгаль орчныг хамгаалах сөрөг нөлөөллийг бууруулж нөхөн сэргээх ажлыг менежментийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.	Жилийн туршид	Хуалян ХХК-ний захиргаа	БОНБУ-ний тухай хууль
БОНБайдлын нарийвчилсан үнэлгээнд байгаа зөвлөмж, менежментийн төлөвлөгөө хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тухайн жилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хийх ажлын төлөвлөгөөг гарган төсөв боловсруулан үйлдвэрийн жилийн санхүүгийн тооцоонд оруулж батлуулж 5700000 төгрөг зарцуулна.	Жилийн туршид	Хуалян ХХК-ний захиргаа	MNS 5917 : 2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Тоосгоны үйлдвэр, шаврын карьерт ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслэлээр хангаж, аюулгүй ажиллах дүрэм журамд сургаж, сургалт зохион байгуулж, тэдний эрүүл мэндэд хяналт тавьж, илчлэг хоол хүнсээр хангаж ажиллагсдын амьдрах орчны цэвэрлэгээг байнга тогтмолжуулж тоосжилтыг багасгаж ажиллана.	Төлөвлөгөө ний дагуу хийнэ.	ХХАА инженер Ш. Давааням БОХариуцсан ажилтан Н. Отгондорж	Агаарын бохирдлыг бууруулах бууруулах тухай 2011
Дүүрэг нийслэл улсын чанартай байгаль хамгаалах сургалт семинарт Байгаль орчин хариуцсан ажилтаныг оролцуулж байна.		БОХариуцсан ажилтан Н. Отгондорж	БОНБУ-ний тухай хууль
Ажиллагсдыг байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагаа явуулах сургалтанд хамруулна.	Үйлдвэрлэл эхлэхийн өмнө зохион	Н. Отгондорж	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995

	байгуулна.		
Үйлдвэрийн орчны тоосжилт, ус , хөрсний шинжилгээг МХХ-т хүсэлт гаргаж шинжлүүлж хяналт тавин ажиллана.	2023 оны 05-08 сард	Менежер О. Сүхбаатар	MNS 5885 : 2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 900:2005-Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 5850:2008 – хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийслэлийн БОГ-т хандаж нөхөн сэргээлтийн ажлаа шалгуулж дүгнэлт гаргуулж ажиллана.	10 сард	Менежер О. Сүхбаатар	БОНХөгжлийн Сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаал
Байгаль орчны менежментийн тухайн жилийн ажлын тайлан мэдээ болон 2023 оны төлөвлөгөөг БОАЖЯ-д хүргүүлнэ.	11 сарын 30	Менежер О. Сүхбаатар	Ашигт малтмалын тухай хууль 2006 Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995

6. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тухайн орчинд зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт (ОХШХ) заасан дагуу агаар, ундны ус, хөрсний шинжилгээг 2023 онд хийлгэнэ. /Шинжилгээний дүнг хавсаргана.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах ОХШХ нь тус төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичгийн нэг юм.

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад хяналт шинжилгээний ажлыг энд тусгасан хугацаа болон аргачлалын дагуу үргэлжлүүлэн хийх нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шуурхай тогтоохоос гадна түүний олон жилийн судалгааны мэдээ материал нь нутгийн хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх ус зэрэг экосистемийн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцан шүтэлцээг тодорхойлж, тэдгээрийн талаарх шинжлэх ухааны мэдлэгийг бий болгох чухал хэрэглэгдэхүүн болно.

Жил бүр хийгдсэн хяналт, шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж үзэж байх нь цаашдаа байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт оршин суугчдыг төслийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүүндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналт, шинжилгээ хийж байгаа объектоо бүрэн хамарч байгаа эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

АГААРЫН БОХИРДОЛТЫГ БУУРУУЛАХАД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал Мян.төг	Хариуцах эзэн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Зам, талбайг тэгшлэх, услах, ургамалжуулах замаар тоосжилтыг багасгаж ажиллана.	Төслийн хугацаанд	БОНБНҮнэл гээнд заасан дагуу	Менежер О. Сүхбаатар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисынхүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
2	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгахын тулд янданд шүүр тавина.	1 удаа	200.0	Мех/инженер Ш. Давааням	MNS 4585:2007 Агаарын чанар
3	Ажиллагсдад агаарын бохирдол, хөрс ургамал, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх, түүнийг бага байлгах арга боломжийн талаар сургалт хийнэ.	Ажил эхлэхийн өмнө	150.0	БОХ ажилтан Н. Отгондорж	БОНБУ-ний тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
4	Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчидад нормын сүү, цагаан идээгээр хангана.	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод зардал	Менежер О. Сүхбаатар	Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль 2006
5	Баюуны янданд шүүр тавих ингэснээр бааюунаас гарах утааг багасгаж, бүрэн шатаалт хийлгэх	2023 онд		Мех/инженер Ш. Давааням	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисынхүлцэх

					хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
6	Ордын орчинд тоосжилт үүсгэхгүй байх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.	Жил бүр	Дотоод зардлаар	БОХ ажилтан Н. Отгондорж	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
7	Автомашин, өөрөө явагч хэрэгслийн хөдөлгүүрийн байдалд байнга хяналт тавьж, утаа тортог зөвшөөрөгдөх хэмжээнээс их болох үед засварлах буюу солих арга хэмжээ авна.	Жил бүр	Дотоод зардлаар	Механик инженер Ш. Давааням	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисынхүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
8	Тоосго шатаах шахмал түлш хадгалах агуулах барих	Хяналт тавин ажиллах	Дотоод зардлаар	Менежер О. Сүхбаатар	Агаарын бохирдлыг бууруулах тухай 2011
9.	Байгаль Орчны Хэмжил зүйн Төв лабораторид агаарын тоосжилтийн шинжилгээг өгөх		Мониторингийн зардал		MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисынхүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
Бүгд			350.0		

ХӨРСНИЙ БОХИРДОЛТЫГ БУУРУУЛАХАД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцах эзэн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хатуу хог хаягдал болон бохир усыг төвлөрсөн цэгт зайлуулахад	2023 оны 6 сард	396.0	Гүйцэтгэх захирал Б. Хасбаатар	Хог хаягдлын тухай хууль 2004
2.	Машин техникийн үйлчилгээ, засварыг талбайг сайжруулахад	2023 5 сард	50.0	Механик инженер Ш. Давааням	MNS 3297:1991- Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм
3.	Бохир усыг “ Чандмань-Налайх”ОНӨГ-тай байгуулсан гэрээний дагуу зөөвөрлүүлнэ.	2023 оны турш	198.0	Менежер Н. Отгондорж	Хог хаягдлын тухай хууль 2004
4.	Карьерт хүн, мал, ан амьтан унахаас сэргийлэх арга хэмжээнд тэмдэг тэмдэглэгээ хийлгэх / Жил бүр/	2023 оны турш	Дотоод зардал	Менежер О. Сүхбаатар	Газрын тухай хууль 2002
5.	Үйлдвэрийн орчинд модны суулгац тарих	2023 оны 5.9 сар	Дотоод зардал	Гүйцэтгэх захирал Б. Хасбаатар	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
6.	Суулгац суулгасан газрыг хамгаалсан хашаа, хайс барих	2023 онд	Дотоод зардал	Гүйцэтгэх захирал Б. Хасбаатар	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995
7.	Байгаль Орчны Хэмжил зүйн Төв лабораторид агаарын тоосжилтийн шинжилгээг өгөх		Монито рингийн зардал		Газрын тухай хууль 2002
	Бүгд		644.0		

УСАН ОРЧНЫ БОХИРДОЛТ БУУРУУЛАХАД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцах эзэн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Уурхай дотор болон уурхайн ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд)	2023 оны Үйлдвэр лэлтийн явцад	200.0	Механик инженер Ш. Давааням	Усны тухай хууль MNS 5850:2008 –хөрсний чанар. Хөрсбохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.	Тоосжилтыг дарах зорилгоор автозам, уурхайн карьерын мөргөцөг, шинэ овоолгын тоосжилтоос хамгаалах усалгааны зардалд	Үйлдвэр лэлтийн явцад	Тоолуур ын заалтаа р төлнө	Гүйцэтгэх захирал Б. Хасбаатар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
3.	Шатах тослох материал алдах, асгах, хог хаягдал үерийн урсацаар дамжин гадаргын усыг бохирдуулж болзошгүй анхаарч ажиллана.	Үйлдвэр лэлтийн явцад	Дотоод зардал	Механик инженер Ш. Давааням	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулагч бодисынхүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага
4.	Хучилтгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах, тэмдэгжүүлэх	5 сард	100.0	Менежер О. Сүхбаатар	Газрын тухай хууль 2002
	Байгаль Орчны Хэмжил зүйн Төв лабораторид агаарын тоосжилтийн шинжилгээг өгөх		Мониторингийн зардал		Усны тухай хууль
Бүгд			300.0		

2023 оны байгаль орчныг хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусгах экологийн мониторингийн албаар хийлгэх мониторингийн ажлын хэмжээ, холбогдох зардал

дд	Ажлын нэр Жилд хийлгэх шинжилгээ	Нэгжийн мян.төг	Нийт зардал мян. төг	/Жилд нэг удаа/ 3цэг х 31удаа
1	Агаарын сорьц шинжилгээ хийлгэх /Жилд нэг удаа/	4цэг х 1 удаа	62.0	78.0
2.	Усны шинжилгээ хийлгэх /худгийн усанд/	1 цэг х 1удаа	40.0	40.0
3.	Хөрсний шинжилгээ хийлгэх	2 цэг х1удаа	40.0	40.0
	ДҮН			158.0

БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ЗАРДАЛД НИЙТ 3092.2 МЯНГАН ТӨГРӨГ ЗАРЦУУЛАХ БОЛНО.

Төслийн 2023 онд хийх ажил

Шаврын олборлолтыг өөрийн үйлдвэрт ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн хүчин чадлыг үндэслэн 2023 оны уулын ажлаар **0.219 га талбайд 5260 м3 хөрс хуулалт хийж 7220м3 шавар, урд ондуудад олборлож нөөцөлсөн 3190м3 шавартай нийт 10410м3 шавраар 3.0 сая тоосго үйлдвэрлэхээр төлөвлөж** байна.

2023 оны уулын ажлын төлөвлөгөө /сараар /

Хийгдэх ажлууд	х/н	2023 он						2023 он
		5	6	7	8	9	10	
Хөрс хуулалт	М ³	560	800	1500	2400			5260
Шавар олборлолт	М ³		1700	1700	2023	1800		7220
Тоосго үйлдвэрлэлт	Мян.шир		600.0	600.0	1000.0	800.0		3000.0

“Налайхын зүүн жигүүр”-ын тоосгоны шаврын ордыг ашиглах төсөл нь уурхайн байгуулалт, олборлолт, боловсруулалт, хаалтын үе шатуудыг дамжин хэрэгжих бөгөөд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны системд үндэслэн тухай бүрт тохирсон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг төлөвлөн олон улсын болон Монгол улсын стандартын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

